



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/01/СТА-ТБОӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2021 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас:70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитор: Т.Болормаа Утас: 70357955 Цахим хаяг:bolormaat@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	0
4	1
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ.....	1
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан	2
3.Аудитын тайлан.....	3
3.1. Ерөнхий зүйл.....	3
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	3
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	3
3.4. Материаллаг байдал	4
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	4
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	5
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	7
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	7
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
3.10. Аудитын илрүүлэлт.....	8
Залруулсан алдаа.....	8
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	9
4. Менежментийн захидал	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	12

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 82.

танай _____-ны № _____-т

ОРХОН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц.БАТЗОРИГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх

талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	348,520,550.98	342,721,293.48
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	97,447,532.08	89,115,211.71
1.1.2	Дансны авлага	206,517,133.31	186,798,149.32
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,103,290.4	
1.1.4	Бусад авлага	453,870.0	180,294.18
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	42,998,625.19	66,627,638.27
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	712,704,605.73	646,551,951.34
1.2.1	Үндсэн хөрөнгө	427,945,495.71	362,232,841.32
1.2.2	Биет бус хөрөнгө	284,520,000.0	284,080,000.0
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	239,110.02	239,110.02
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	712,704,605.73	646,551,951.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,061,225,156.71	989,273,244.82
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	815,904,251.67	750,994,746.54
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	189,010,295.67	124,100,790.54
2.1.1.1	Дансны өглөг	10,454.67	10,454.67
2.1.1.2	Цалингийн өглөг	3,697,747.0	5,000.0
2.1.1.3	Татварын өр	185,302,094.0	124,057,990.43
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		27,345.44
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	626,893,956.0	626,893,956.0
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	626,893,956.0	626,893,956.0
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	626,893,956.0	626,893,956.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	815,904,251.67	750,994,746.54
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	629,227,688.87	629,227,688.87
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	255,903,164.14	255,903,164.14
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(639,809,947.97)	(646,852,354.73)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	245,320,905.04	238,278,498.28
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,061,225,156.71	989,273,244.82

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,135,607,876.36	1,206,393,070.0
2	Борлуулалтын өртөг	967,005,829.52	938,306,273.47
3	Нийт ашиг(алдагдал)	168,602,046.84	268,086,796.53
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	4,220,152.71	1,742,084.03
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		7,282,443.0
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	169,177,225.5	214,513,647.68
11	Санхүүгийн зардал		27,386,129.31
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	169,728.08	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	3,475,245.97	35,211,546.57
19	Орлогын татварын зардал	347,524.6	3,521,154.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)		
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,127,721.37	31,690,391.91
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	3,127,721.37	31,690,391.91
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(642,937,669.34)	242,193,183.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					3,127,721.37	3,127,721.37
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(639,809,947.97)	245,320,905.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(38,732,798.68)	(38,732,798.68)
Залруулсан үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(678,542,746.65)	206,588,106.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					31,690,391.92	31,690,391.92
Зарласан ногдол ашиг						
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(646,852,354.73)	238,278,498.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,258,664,092.0	1,359,176,197.8
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,257,999,592.0	1,321,063,377.0
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		9,217,817.0
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	664,500.0	28,895,003.8
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,306,272,948.2	1,365,780,702.2
	Ажиллагчдад төлсөн	285,183,666.0	369,887,950.0
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,115,816.6	100,626,444.8
	Бараа материал худалдан авахад төлсөн	360,638,695.4	359,756,152.9
	Ашиглалтын зардалд төлсөн	9,356,739.6	28,320,596.8
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	274,997,887.0	258,495,547.9
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	163,091,937.1	211,849,128.3
	Даатгалын төлбөрт төлсөн	2,319,156.0	9,141,894.5
	Бусад мөнгөн зарлага	120,569,050.6	27,702,987.0
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(47,608,856.2)	(6,604,504.4)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	4,220,152.7	1,742,084.03
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		2,999,900.0
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,999,900.0
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,220,152.7	(1,257,815.97)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		470,000.0
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		470,000.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		470,000.0
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(43,388,703.4)	(8,332,320.4)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	140,836,235.5	97,447,532.1
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,447,532.1	89,115,211.7

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэм жиг нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		/төгрөг/	
				төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	1,080,856.9	1,157,683.7	1,215,417.6	(57,733.9)	105.0
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	мян.төг	767,067.2	782,408.5	1,098,846.5	(316,438.0)	140.4
	Бусад	мян.төг	313,789.7	375,275.2	116,571.1	258,704.1	31.1
2	Нийт зардал	мян.төг	1,058,208.3	1,134,582.1	1,180,206.0	(45,623.9)	104.0
	Үйл ажиллагааны зардалд	мян.төг	161,500.6	219,940.2	241,899.7	(21,959.5)	110.0
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	22,648.6	23,101.6	35,211.6	(12,110.0)	152.4
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	20,383.7	20,791.4	31,690.4	(10,899.0)	152.4
5	Төсвийн төлбөр	мян.төг	172,766.8	178,092.1	297,984.9	(119,892.8)	167.3
	а. Орлогын татварт	мян.төг	2,264.9	2,310.2	1,535.8	774.4	66.5
	б. НӨАТ	мян.төг	98,259.7	100,224.9	157,283.6	(57,058.7)	156.9
	в. НДШ	мян.төг	49,676.1	50,669.6	108,025.1	(57,355.5)	213.2
	г. ХХОАТатварт	мян.төг	20,142.1	20,544.9	23,732.5	(3,187.6)	115.5
	д. Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	0.0	1,870.0	2,366.2	(496.2)	126.5
	е. Газрын төлбөр	мян.төг	-	-	2,028.5	(2,028.5)	
	ё. Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,524.0	1,554.5	2,095.2	(540.7)	134.8
	ж. Бусад татварт	мян.төг	900.0	918.0	918.0	-	100.0
6	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	2,269.8	4,075.8	470.0	3,605.8	11.5
7	Нийт авлага	мян.төг	182,080.0	160,000.0	186,978.4	(26,978.4)	116.9
8	Нийт өглөг	мян.төг	756,893.5	726,893.5	750,984.2	(24,090.7)	103.3
	Үүнээс: богино хугацаат өглөг	мян.төг	130,000.0	100,000.0	124,090.3	(24,090.3)	124.1
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	0.98	0.98	0.97	0.0	99.1
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	10,000.0	8,000.0	7,999.9	0.1	100.0
11	Ажиллагсдын тоо	хүн	37.0	38.0	38.0	-	100.0
12	Цалингийн сан	мян.төг	326,656.7	405,969.0	413,195.8	(7,226.8)	101.8
13	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	735.71	890.28	906.1	(15.8)	101.8

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал Ц.Батзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтыг сайжруулах, найдваргүй авлага өр төлбөрийг барагдуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 11-наас 2020 оны 03 дугаар сарын 24-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон АЗЗА нь Төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Автозам, замын байгууламжийг барих, засварлах
- Тээврийн бусад туслах үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Зам тээврийн яамнаас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,206,393.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 24,127.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,951.5 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97,447.5	89,115.2	(8,332.3)
Авлага	208,074.4	186,978.4	(21,096.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42,998.6	66,627.6	23,629.0
Үндсэн хөрөнгө	712,704.6	646,551.9	(66,152.7)
Нийт хөрөнгийн дүн	1,061,225.2	989,273.2	(71,952.0)
Өр төлбөр	815,904.3	750,994.7	(64,909.6)
Эздийн өмч	629,227.7	629,227.7	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,061,225.2	989,273.2	(71,952.0)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 89,115.2 мянган төгрөг болж өмнөх оноос 8,362.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,359,536.8 мянган төгрөгийн орлого орж 1,365,380.8 мянган төгрөгийн зарлага гарснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 186,978.4 мянган төгрөг болж 21,095.9 мянган төгрөгөөр буурсан нь Булган АЗЗА ТӨХК-аас авах авлага шүүхийн шийдвэрийн дагуу шилжиж орсноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн, он удаан жил болсон 162,938.1 мянган төгрөгийн байгууллагаас /Харбин ХХК, Капитал банк/-аас авах авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 162,938.1 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй авлага болох эрсдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,627.6 мянган төгрөг болж 23,629.0 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 7,230.1 мянган төгрөг, бусад хангамжийн бараа материалын үлдэгдэл 15,098.5 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 2,999.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 7,100.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслээр хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст 21,172.5 мянган төгрөгийн ажилчдын өвлийн гутал хувцас, бодис давс, хуулга, авто грейдерийн хутга худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь өвөлжилтийн бэлтгэл хангасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 646,551.9 мянган төгрөг болж 66,152.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгө 33,894.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан элэгдэл 50,645.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрч, өмнөх онуудад тээврийн хэрэгсэл 8,015.9, мянга, машин тоног төхөөрөмж 24,918.7 мянга, тавилга эд хогшил 17,788.5 мянга, нийт 50,723.3 мянган төгрөгөөр өсгөж бүртгэснийг аудитын явцад залруулж, барилга байгууламжаас 10,000.0 мянган төгрөгийг капиталжуулсныг буцааж бараа материалд бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,000.0 мянган төгрөг, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 27,894.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс өмнөх онд 10,000.0 мянган төгрөгийн бараа материалаас барилга байгууламжийн дансанд капиталжуулсан хөрөнгийг буцааж бараа материалын дансанд шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 750,994.7 мянган төгрөг болж 64,909.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад хуримтлагдсан нэмэгдсэн өртгийн албан татвараас төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 2008-2009 онуудад үүссэн Кувейтийн сангийн 626,893.9 мянган төгрөгийн өр байна.

Бусад аж ахуйн нэгжийн орлогын татварын өр 3,118.7 мянга, ХАОАТ-ын өр 8,840.7 мянга, ҮЭ-ийн өглөг 5.0 мянга, шуудан холбоо 27.3 мянга, дансны өглөг 10.5 мянга, НӨАТ-ын өр 112,098.6 мянга, нийт 124,100.8 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 629,227.7 мянган төгрөгт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 255,903.2 мянган төгрөгт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл (639,809.9) мянган төгрөг байснаас тайлант оны ашиг 31,690.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн залруулгатай холбоотой (38.732.8) мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүнд хаах бичилт хийснээр хуримтлагдсан ашиг (646.852.3) мянган төгрөг болсон байна. Залруулгын талаар В30102 маягтад дэлгэрэнгүй тусгасан болно.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 17-ны 588 дугаар тогтоолоор Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,157,683.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,134,582.1 мянган төгрөгөөр, ашгийг 20,791.4 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 2 арга хэмжээнд 8,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 1,206,393.1 мянга, хүүгийн орлого 1,742.1 мянга, бусад орлого 7,282.4 мянга нийт 1,215,417.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,180,206.1 мянган төгрөгийн зардал гарган, 31,690.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт орлого	Мян.төг	1,080,856.9	1,157,683.7	1,215,417.6	(57,733.9)	105.0
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	Мян.төг	767,067.2	782,408.5	1,098,846.5	(316,438.0)	140.0
	Цэвэр борлуулалт	Мян.төг	313,789.7	375,275.2	116,571.1	258,704.1	31.1
3	Нийт зардал	Мян.төг	1,058,208.3	1,134,582.1	1,180,206.0	(45,623.9)	104.0
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	Мян.төг	896,707.7	914,641.9	938,306.3	(23,664.4)	102.6
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	Мян.төг	161,500.6	219,940.2	241,899.7	(21,959.5)	110.0
	в) Хөрөнгө оруулалт их засвар	Мян.төг	10,000.0	8,000.0	7,999.9	0.1	100.0
4	Цэвэр ашиг, алдагдал	Мян.төг	20,383.7	20,791.4	31,690.4	(10,899)	152.4

Нийт орлогын гүйцэтгэл 1,215,417.6 мянган төгрөг болж төлөвлөснөөс 57,733.9 мянган төгрөг буюу 5 хувиар давж биелсэн нь бусад гэрээт ажил болон банкны эхний 5 сарын хүүгийн орлого нэмж орсноос нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,180,206.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 45,623.9 мянган төгрөг буюу 4 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь гэрээт нэмэлт ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор материалын зардал, цалингийн зардал нэмж гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2 нэр төрлийн 3 ажилд өөрийн эх үүсвэрээс 8,000.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 31,690.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,899.0 мянган төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны орлого 5 хувиар давж биелсэн, зардал 4 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 315 дугаар тогтоолын дагуу тайлант онд 470 мянган төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 15 хувийг төвлөрүүлэхээс 470.0 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 3, Зам тээврийн яамнаас 3, хараат бус 9, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 5 удаа зохион байгуулж 5 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой журмыг шинэчлэн боловсруулж батлаагүй байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 33,169.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 29,101.8 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 24,240.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 3,514.8 мянган төгрөг, томилолтын зардалд 621.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 640.0 мянган төгрөг, хараат бус гишүүн сонгон шалгаруулах зарыг өдөр тутмын сонинд хэвлүүлэх зардалд 86.0 мянган төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 99 мэдээллийг байршуулаагүй байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	13,187.4	1	5,902.0	44.7%
Албан шаардлага	5	17,062.6	4	9,724.8	57.0%
Зөвлөмж	3	850.0	3	850.0	100%
Нийт дүн	10	31,100.0	7	16,476.8	

Хэрэгжилт хангагдаагүй төлбөрийн акт, албан шаардлага:

- 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар шатахуун нийлүүлдэг НИК ХХК-тай тооцоо нийлсэн актаар 7,285.4 мянган төгрөгийн өглөгтэй байтал уг өглөгийг санхүүгийн тайланд бүртгэлд тусгаагүй, байгууллагын тооцооны нягтлан, гүйцэтгэх захирал нараас тодруулахад ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч нь харилцагч байгууллагаас бэлнээр мөнгийг нь гаргуулж авсан нь тогтоогдож 2020 оны 01 дүгээр сард байгууллагын данснаас харилцагч байгууллагын дансанд шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон боловч тухайн үеийн нягтлан бодогчоор хохирлыг төлүүлээгүй, 2020 оны шатахууны зардалд тайлагнасан байна.

2. Компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангийн өөрийн хөрөнгийн дүнгүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн тул ТУЗ-аар шийдвэрлүүлэн, хууль, журамд нийцүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэх тухай зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлтийг санхүүгийн аудитаар шалгахад зөрчил арилаагүй, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байсан тул албан шаардлага хүргүүлсэн. Орхон АЗЗА ТӨХК-аас ТУЗ-д албан бичгээр шийдвэрлэх тухай хүсэлт хүргүүлсэн боловч ТУЗ хуралдаж шийдвэрлээгүй хэвээр байна.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 123,710.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 99,456.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,482.0 төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 10,772.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хуримтлагдсан элэгдлийн зардлыг тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 69,001.9 мянган, тавилга эд хогшлын хуримтлагдсан элэгдлийг 15,961.5 мянган төгрөгийн илүү, тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг 74,571.3 мянган төгрөгөөр дутуу нийт 10,392.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасныг энэ оны санхүүгийн тайлангаар залруулав.
2. Өмнөх онуудад үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгсэл 8,015.9 мянга, тоног төхөөрөмж 24,918.7 мянга, тавилга эд хогшил 17,788.6 мянга нийт 50,723.3 мянган төгрөгөөр өсгөн нэмэгдүүлсэн байсныг залруулав.
3. Бараа материалын дансанд 370.1 мянган төгрөгийн махны үлдэгдлийг өмнөх онд зарцуулсныг зарлагадаагүй үлдэгдлээр байсныг энэ онд залруулах бичилт хийж өмнөх үеийн үр дүнд хаасан.
4. Өмнөх онд авлагаар бүртгээгүй ажилтнаас авах 108.8 мянган төгрөгийг цалингаас суутгасныг өмнөх оны үр дүнд хаах бичилт хийж залруулав.
5. Санхүүгийн программ хангамжийн хуримтлагдсан элэгдэл 220.0 мянган төгрөгийг буруу бүртгэснийг залруулж бүртгүүлсэн.
6. Өмнөх оны ногдол ашгийн 470.0 мянган төгрөгийг өмнөх оны үр дүнд бууруулах бичилт хийлгэсэн.
7. Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл өөрчлөгдсөн, мөнгөн гүйлгээний тайлангийн хүүгийн орлого буруу тайлагнагдсаныг аудитын явцад залруулсан.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, байгууллагад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд касснаас зарцуулсан 928.4 мянган төгрөг, харилцахаас зарцуулсан 5,268.2 мянга, нийт 6,196.6 мянган төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримт хангалтгүй, зарим гүйлгээнд дан бэлэн мөнгөний зарлагын баримт, төлбөрийн хүсэлт хавсаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Орхон аймгийн Цагдаагийн газарт 2021.03.18-ны өдрийн 56 тоот албан бичгээр нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Т.Ганболдтой холбогдох цалин хөлсийг илүү тооцоолж авсан 8,960.9 мянган төгрөгийн хэргийг шилжүүлсэн байна. Харин өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны зардалтай холбоотой 7,285.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоосон бөгөөд тайлант онд биелэлт хангагдаагүй, байгууллагын данснаас төлж, тайлант оны зардлаар тайлагнасан. Уг төлбөрийн актыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, байгууллагыг хохиролгүй болгох талаар нэмж нэхэмжлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих”, 20.2.13-т “эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах”, Компанийн тухай хуулийн 84.4-т Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 99 мэдээллийг огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Орхон АЗЗА ТӨХК-ийн нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Т.Ганболд нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар урьдчилгаа цалинг өөртөө илүү шилжүүлж, банканд очих жагсаалт болон байгууллагад үлдэх анхан шатны баримтыг 2 өөрөөр үйлдсэн байсныг илрүүлж 3,510.0 мянган төгрөгийг төлбөрийн актыг байгууллагаас төлөөд өөрийн цалингаас суутгаагүй, 2020 онд цалин илүү авсан 5,030.9 мянган төгрөг, удаан жилийн нэмэгдэл илүү тооцоолж авсан 420.0 мянган төгрөгийг өөртөө илүү авсныг Цагдаагийн газарт 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 56 тоот албан бичгээр шилжүүлэн шалгуулах хүсэлт өгсөн байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд касснаас 1,580.0 мянган төгрөг, харилцахаас 6,880.0 мянган төгрөгийг тээврийн зардал /цемент, битум, давс тээвэрлэх/-д зарцуулахдаа тээврийн хэрэгслийн жолоочийн өргөдөл болон иргэний үнэмлэхийг хавсаргасан нь анхан шатны баримтын иж бүрэн байдал хангалтгүй, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон тээвэр түрээслэх гэрээ байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: Ашиг сонирхлын зөрчил үүсэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгслээр цемент, битум, давс зэргийг тээвэрлэж, тээврийн хөлсийг олгохдоо анхан шатны баримтын иж бүрэн байдлыг хангаж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 59 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд хоолны тооцоо 180.3 мянга, иргэн Т.Ганболдоос 8,960.9 мянга, Капитал банк 2,938.1 мянга, Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК-аас 8,771.2 мянга, Төгс цас ХХК-аас 4,010.0 мянга, Харбин ХХК-аас 160,000.0 мянга, иргэн Цэвэлмаагаас 2,118.0 мянган төгрөг нийт 186,978.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Харин өглөг дансанд Кувейтийн сангийн 626,893.9 мянга, МЦХ-ны 27.3 мянга, ХАОАТ-ын 8,840.7 мянга, ААНОАТ-ын 3,118.7 мянга, НӨАТ-ын 112,098.6 мянга, ҮЭ-ын 5.0 мянга нийт 750,984.3 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Бүртгэлтэй байгаа авлага өр төлбөрийг насжилт ихтэй, найдваргүй авлага өр төлбөр үүсгэхгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалттай нийцээгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:Найдваргүй авлага, өр төлбөр үүсэх

2.3. Өгсөн зөвлөмж: Бүртгэлтэй байгаа авлага өр төлбөрийг бүрэн барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 59 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ерөнхий чиглэл

3.1 Илрүүлэлт: Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

баримт бичгийг” мөрдөж эхэлсэн байна. Уг НБББББ-т ногдол ашгийг хэрхэн бүртгэх талаар огт тусгагдаагүй байна.

3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлээдэх

3.3 Өгсөн зөвлөмж: Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т тусгагдаагүй, өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 59 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Т.БОЛОРМАА

6117143690

САА0073 2021.03.06

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/1/СТА-ТБООААН
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон АЗЗА ТӨХК		Мян.төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, байгууллагад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд касснаас зарцуулсан 928.4 мянган төгрөг, харилцахаас зарцуулсан 5,268.2 мянга, нийт 6,196.6 мянган төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримт хангалтгүй, зарим гүйлгээнд дан бэлэн мөнгөний зарлагын баримт, төлбөрийн хүсэлт хавсаргасан	6,196.6	Албан шаардлага	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг, Т.Батдорж
2	Орхон аймгийн Цагдаагийн газарт 2021.03.18-ны өдрийн 56 тоот албан бичгээр нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Т.Ганболдтой холбогдох цалин хөлсийг илүү тооцоолж авсан 8,960.9 мянган төгрөгийн хэргийг шилжүүлсэн байна. Харин өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны зардалтай холбоотой 7,285.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоосон бөгөөд тайлант онд биелэлт хангагдаагүй, байгууллагын данснаас төлж, тайлант оны зардлаар тайлагнасан. Уг төлбөрийн актыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, байгууллагыг хохиролгүй болгох талаар нэмж нэхэмжлээгүй	7,285.4	Албан шаардлага	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг, Т.Батдорж
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 99 мэдээллийг огт байршуулаагүй		Албан шаардлага	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг, Т.Батдорж

**Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	үнэмлэхийг хавсаргасан нь анхан шатны баримтын иж бүрэн байдал хангалтгүй, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон тээвэр түрээслэх гэрээ байгуулаагүй байна				
	Тайлант онд хоолны тооцоо 180.3 мянга, иргэн Т.Ганболдоос 8,960.9 мянга, Капитал банк 2,938.1 мянга, Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК-аас 8,771.2 мянга, Төгс цас ХХК-аас 4,010.0 мянга, Харбин ХХК-аас 160,000.0 мянга, иргэн Цэвэлмаагаас 2,118.0 мянган төгрөг нийт 186,978.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Харин өглөг дансанд Кувейтийн сангийн 626,893.9 мянга, МЦХ-ны 27.3 мянга, ХАОАТ-ын 8,840.7 мянга, ААНОАТ-ын 3,118.7 мянга, НӨАТ-ын 112,098.6 мянга, ҮЭ-ын 5.0 мянга нийт 750,984.3 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Бүртгэлтэй байгаа авлага өр төлбөрийг насжилт ихтэй, найдваргүй авлага өр төлбөр үүсгэхгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна	1,842.5	Зөвлөмж	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг, Т.Батдорж
4	Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар баталсан "Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж эхэлсэн байна. Уг НБББББ-т ногдол ашгийг хэрхэн бүртгэх талаар огт тусгагдаагүй байна.	470.0	Зөвлөмж	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг, Т.Батдорж
	ДҮН	24,254.5			

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Т.БОЛОРМАА





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 66/60 099-2021/01/СТА-ТБОО ААН Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, байгууллагад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд касснаас зарцуулсан 928.4 мянган төгрөг, харилцахаас зарцуулсан 5,268.2 мянга, нийт 6,196.6 мянган төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримт хангалтгүй, зарим гүйлгээнд дан бэлэн мөнгөний зарлагын баримт, төлбөрийн хүсэлт хавсаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал Ц.Батзориг, ерөнхий нягтлан бодогч Т.Батдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 61/61 ОМ/2021/01/СГ-ТБСВ/АНН Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Цагдаагийн газарт 2021.03.18-ны өдрийн 56 тоот албан бичгээр нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Т.Ганболдтой холбогдох цалин хөлсийг илүү тооцоолж авсан 8,960.9 мянган төгрөгийн хэргийг шилжүүлсэн байна. Харин өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны зардалтай холбоотой 7,285.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоосон бөгөөд тайлант онд биелэлт хангагдаагүй, байгууллагын данснаас төлж, тайлант оны зардлаар тайлагнасан. Уг төлбөрийн актыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, байгууллагыг хохиролгүй болгох талаар нэмж нэхэмжлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих", 20.2.13-т "эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах", Компанийн тухай хуулийн 84.4-т Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 7,285.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг буруутай этгээдээр төлүүлж, байгууллагыг хохирлыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал Ц.Батзориг, ерөнхий нягтлан бодогч Т.Батдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 62/62 ДАА-2021/01 СГД-ТӨХК-ийн Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 99 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, этрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сайтад төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг арилгаж,

биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь
Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг
хэрэгжүүлж ажиллахыг Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал Ц.Батзориг, ерөнхий
нягтлан бодогч Т.Батдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА